



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар Д/532

Хэрлэн сум

“Боловсролын шинэ сэргэлт-Хэнтий”
зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц” хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын ерөнхий хууль болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг сургууль, цэцэрлэгийн багш нарт сурталчлах ажлын хүрээнд “Боловсролын шинэ сэргэлт-Хэнтий” зөвлөгөөнийг зохион байгуулахад нь зориулан 8,300,000 (найман сая гурван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шинээр батлагдсан хууль, тогтоомж шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 18-ны өдрийн
А/БСР дугаар захирамжийн хавсралт

Зөвлөгөөний төсөв

№	Зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хоол	500 хүн	15000	7,500,000
2	Ус	500 хүн	1000	500,000
3	Хан Хэнтий чуулгын түрээс		300,000	300,000
	Нийт			8,300,000